

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ АРВАЙХЭЭР НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.11.15

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтанцомын баталсан 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Өвөрхангай аймаг дахь Арвайхээр нисэх буудлын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 26/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн. Аудитын явцад ахлах аудитор Л.Жаргалсайхан аудитын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаас гадна зарим үйл ажиллагаанд оролцсон.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Өвөрхангай аймаг дахь Арвайхээр нисэх буудлын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

ИНЕГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/1062 дугаар тушаалаар баталсан “Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний салбар, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, үнэлэх журам”-ын дагуу 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ИНУТ-ийн даргаар батлуулаагүй, хагас жил болон жилийн эцсийн байдлаар биелэлтийг үнэлээгүй.

МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7-д заасны дагуу ИНУТ нь тус нисэх буудлын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөгөөний биелэлтийг хянаж хагас жилээр үнэлээгүй байна.

Тушаалын болон албан бичгийн төсөл боловсруулах, түүний үнэн зөв, албан ёсны хүчинтэй байдлыг хангах үйл ажиллагаанд Монгол хэлний зөв бичих дүрэм, стандартыг мөрдөөгүй, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-д заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь бичиг хэрэг хариуцсан ажилтан заавар, журмаа уншиж судлаагүй, мэдлэггүй байгаатай холбоотой байна.

Явуулсан албан бичгийг боловсруулдаа “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.1.7.4.1 болон 5.7.1 дэх заалтуудыг мөрдлөг болгон ажиллаагүй.

Арвайхээр нисэх буудлын шатахууны лаборант (аж ахуйн нярав хавсарсан) нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 7.2, ИНЕГ-ын НБББББ-ийн 4.1.5-д тус тус заасан кассын

дэвтэр, мөнгөн орлого ба зарлагын журналыг өдөр тутам бэлтгэж буй байдалд хяналт тавихад кассын дэвтэр хөтөлдөггүй зөрчил илэрсэн.

Нисэх буудлын ажилтнууд албан томилолтоор ажиллахаар явах үед зардлын төсвийг батлаагүй байна. Нисэх буудлын Захиргаа, бичиг хэргийн асуудал хариуцсан ажилтан томилолтын хуудсанд томилолтоор ажиллах ажилтны томилолтын хугацааг тэмдэглэдэггүй.

Томилолтын хуудсанд тэмдэглэл хийж буй албан тушаалтан албан томилолтоор ажиллах ажилтан тухайн томилолтоор ажиллах нэгжид хэзээ ирсэн, буцсан тухай тэмдэглэл хийхгүйгээр гарын үсэг зурж, тэмдэг дардаг байна.

ИНЕГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6.2.5.1 дэхь заалтыг сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн нэмэгдэл хөлс олгосон.

Гэрээний төсөл боловсруулах, гэрээ байгуулах, төлөөлөх, бүртгэх, хадгалах, хяналт тавих, дүгнэх үйл явц МУЗГ-ын тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, ИНЕГ-ын даргын баталсан “Иргэний нисэхийн ерөнхий газарт гэрээ байгуулах журам”-ын дагуу явагдахгүй байна. Гэрээний загвар нь тогтсон стандартыг мөрдөөгүй, гэрээнд заавал байх анхдагч бүрдлүүд дутуу, гэрээг дүгнэдэггүй байна.

Шууд худалдан авалттай холбоотой гэрээг байгуулахдаа ижил төрлийн бизнес эрхлэгчдээс үнийн санал, бүтээгдэхүүн, сэлбэг материалын чанар байдлын мэдээллийг авдаггүй.

ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажилтнууд ИНЕГ-ын даргын 2019 оны А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу нэг, хоёр, гурав дахь шатны хяналтыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй. ХАБЭА-н чиглэлээр 2020 онд ажлаас 2 ажил хийгдээгүй, 2021 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд тусгасан ХАБЭА-н тухай хууль, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалыг үндэслэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажлын байруудад хөдөлмөрийн үнэлгээ хийлгэх ажлын биелэлт хангалтгүй байна.

Дотоод аудитын албанаас тус нисэх буудлын үйл ажиллагаанд 2020 онд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 74 хувьтай байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 2, нисэх буудалд 13, нийт 15 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА